

11 Current situation and further trends of Inclusive education in Mongolia

1

Current situation and further trends of Inclusive education in Mongolia

Монгол дахь тэгш хамруулах боловсролын өнөөгийн байдал ба хөгжлийн чиг хандлага

2

Welcome to the Inclusive Education Law course.

Тэгш хамруулах боловсролын тухай хуулийн хичээлд тавтай морилно уу.

3

In this tutorial, we focus on the development of inclusive education in Mongolia.

Энэхүү хичээлээр бид Монгол дахь тэгш хамруулах боловсролын тухай өгүүлнэ.

4

Mongolia ratified the Convention on the Rights of Persons with Disabilities in 2008.

Монгол улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай олон улсын конвенцийг 2008 онд баталсан.

5

This tutorial responds to the following questions:

Энэхүү хичээлээр дараах асуудлуудыг авч үзнэ:

6

What is the conceptual framework of inclusive education in Mongolia?

Монгол дахь Тэгш хамруулах боловсролын үзэл баримтлал юу вэ?

7

Which law reforms and policy developments took place to implement the rights of persons with disabilities in Mongolia?

Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах хуулийн ямар шинэчлэл, бодлогын өөрчлөлтүүд гарсан бэ?

8

What research on the Mongolian situation is carried out?

Монголд энэ чиглэлээр ямар судалгааны ажлууд хийгдсэн бэ?

9

What are the outputs?

Тэдгээрийн үр дүн нь юу вэ?

10

What are the further perspectives on disability policies?

Хөгжлийн бэрхшээлийн талаарх бодлогод цаашдаа ямар өөрчлөлтүүд шаардалагатай вэ?

11

What is the significance of the introduction of inclusive education for the educational system?

Боловсролын тогтолцоонд тэгш хамруулан сургах боловсролыг нэвтрүүлэх нь ямар ач холбогдолтой вэ?

12

The implementation of inclusive education requires changes in education policies,

Тэгш хамруулан сургах боловсролыг хэрэгжүүлэхийн тулд

13

attitudes, learning environments, teacher training methods

боловсролын бодлого, хандлага, сургалтын орчин,

14

and attitudes to accommodate the needs of students with special needs

багш бэлтгэх арга хандлагыг тусгай хэрэгцээтэй суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх хэрэгтэй ба

15

and eliminate barriers impeding their right to education.

тэдний сурч боловсрох эрхийг хангахад учирч буй саад бэрхшээлийг арилгах шаардлагатай.

16

An inclusive education environment is an accessible environment

Тэгш хамруулах боловсролын орчин гэдэг нь

17

that welcomes ALL students in regular classes in their own neighbourhood schools.

БҮХ хүүхэд харьяа нутаг дэвсгэрийн сургуулийнхаа энгийн анги танхимд сурах боломжийг бүрдүүлсэн тохиргоот орчин юм.

18

It provides support and takes care of their learning difficulties.

Тэдний суралцах хэрэгцээнд нийцсэн дэмжлэг үзүүлж, сурах бэрхшээлд нь анхаардаг.

19

It enables students with disabilities to contribute and participate in all aspects of school life.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуулийн бүхий л үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах, оролцох боломжоор хангана.

20

The school environment is designed to foster inclusion of students with disabilities.
Сургуулийн орчин нь тусгай хэрэгцээтэй хүүхдийн хөгжлийг дэмжиж туслахад зориулан зохион байгуулагдсан байна.

21

The entire education environment must be accessible, including buildings and classrooms.
Сургуулийн анги танхим гэх мэтчилэн боловсролын орчин бүхэлдээ тэгш хүртээмжтэй байх ёстой.

22

Curricula must be updated and include a course on inclusive education.
Сургалтын хөтөлбөрүүдийг шинэчилж, тэгш хамруулах боловсролын хичээлийг оруулах ёстой.

23

Teaching methods should be adapted, etc.
Түүчлэн заах арга зүйн хувьд ч мөн тохиргоо хийж өөрчлөх шаардлагатай.

24

Which law reforms and policy developments took place to implement the rights of persons with disabilities in Mongolia?
Монгол улсад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулийн ямар шинэчлэл, бодлогын өөрчлөлтүүд хийгдсэн бэ?

25

In 2017, the Government adopted resolution Number 46
2017 онд МУ-ын Засгийн газраас

26

'On some measures to implement the Law on Human Rights of Persons with Disabilities.'
"ХБХЭХ хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 46 дугаар тогтоол гаргаж баталсан.

27

The state policy on education from 2014 till 2025 develops a forward-looking educational system.
2014-2025 онд төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод ирээдүйг харсан боловсролын тогтолцоог төлөвшүүлэхээр тусгасан.

28

The national program on supporting citizens with disability rights,
"Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, тэдний оролцоо,

29

their participation and development from 2018 till 2022 supports the implementation of the Regulation. хөгжлийг дэмжих 2018-2022” үндэсний хөтөлбөр нь энэхүү тогтоолын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж байна.

30

The Mongolian education policy constitutes a commitment to the implementation of Education 2030, Монгол Улсын боловсролын бодлого нь

31

the so-called Incheon Declaration and Framework for Action Towards inclusive тэгш, хүртээмжтэй чанартай боловсрол болон насан туршийн боловсрол олгох

32

and equitable quality education and lifelong learning for all. Инчоны тунхаглал гэгдэх Боловсрол 2030-ыг хэрэгжүүлэхээр зорьж байна.

33

The Constitution of Mongolia recognizes the right to education of each citizen. Монгол Улсын Үндсэн хуульд иргэн бүрийн сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрсөн байдаг.

34

The Law on Education of 2006 regulates the educational system. 2006 оны Боловсролын тухай хууль нь боловсролын тогтолцоог зохицуулдаг.

35

Article 13.3 of the Law on Primary and Secondary Education Бага, дунд, боловсролын тухай хуулийн 13.3-д

36

states that 'All secondary schools should provide conditions for educating children with disabilities'. "Бүх ерөнхий боловсролын сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургах нөхцлийг бүрдүүлэх ёстой" гэж заасан.

37

Article 13.12 of the Law on Primary and Secondary Education Бага, дунд боловсролын тухай хуулийн 13.12-д

38

states that 'Teachers and social workers working at secondary schools "Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж буй багш, нийгмийн ажилтнууд

39

should have knowledge of special needs education and knowledge of teaching methods and strategies тусгай хэрэгцээт боловсролын тухай, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг сургах, дэмжих арга зүй,

40

for teaching and supporting students with disabilities. стратегийн мэдлэг эзэмшсэн байна." гэж заасан байдаг.

41

According to Article 9. 9 of the Law on Pre-school Education Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.9-д:

42

"In a regular kindergarten, the number of children with a mild type of disability may not exceed two in one group." "Энгийн цэцэрлэгт хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо нэг бүлэгт хоёроос илүү байж болохгүй" гэж заасан байдаг.

43

The Law on the Rights of Persons with Disabilities of 2016 2016 онд баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль" нь

44

makes special education and teaching methods and strategies for teaching and supporting students with disabilities mandatory их, дээд сургууль, коллежийн багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг сургах, дэмжих

45

in curricula of teacher training at universities and colleges. тусгай боловсрол, заах арга зүй, стратегийг заавал тусгана гэж заасан.

46

The MESCS order and statement A/155 ВСШУС-ын сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар

47

regulates the 'Model for the Individual Education Plan and the Procedures for its Development'. "Ганцаарчилсан боловсролын төлөвлөгөөний загвар, түүнийг боловсруулах журам"-ыг зохицуулсан.

48

The MESCS order and statement A/292 ВСШУС-ын сайдын 2019 оны А/292 тушаалаар

49

regulates 'Inclusive education of children with disabilities at regular schools'.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургах"-ыг зохицуулсан.

50

The MESCS order and statement A/425

БСШУС-ын сайдын 2018 оны А/425 тушаалд

51

regulates 'Procedures for the assessment of students and the quality of achievements of students in General Education'.

"Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурлагын чанарын үнэлгээний журам"-ыг зохицуулсан.

52

What research on the Mongolian situation is carried out?

What are the outputs?

Монголын нөхцөл байдлын талаар ямар судалгаанууд хийгдсэн бэ?

Үр дүн нь юу вэ?

53

The project 'Supporting Inclusive education'

'Тэгш хамруулах боловсролыг дэмжих' төсөл нь

54

aimed at identifying the difficulties and needs when creating conditions for inclusive education

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл,

55

for children with disabilities.

хэрэгцээ шаардлагыг тодорхойлоход чиглэгдсэн.

56

The Needs Assessment Survey 'Supporting every child for inclusive education principle in Mongolia'

"Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулан сургах зарчмыг дэмжих нь" судалгаа нь

57

analysed the legal documents

on inclusive education,

тэгш хамруулах боловсролын эрх зүйн баримт бичгүүд,

58

and the difference of understanding of content

and concepts among professionals, teachers and parents.

мэргэжлийн хүмүүс, багш нар, эцэг эхчүүдийн агуулга, үзэл баримтлалын талаарх ойлголтын зөрүүтэй байдалд дүн шинжилгээ хийсэн.

59

The Enrolment Policy Index showed a high rate of school enrolment, Тэгш хамруулан сургах бодлогын индексийн хүрээнд сургуулийн хамрагдалт, хүртээмжийн үзүүлэлт өндөр хувьтай байгаа хэдий ч

60

however low levels of flexibility and adjustment in education. боловсролын уян хатан байдал, зохицуулалт доогуур түвшинд байгааг харуулж байна.

61

Inter-agency cooperation and support between the parties was insufficient. Байгууллага хоорондын хамтын ажиллагаа, талуудын дэмжлэг хангалтгүй байна.

62

The survey 'Supporting Children with Special Needs' dealt with the questions "Тусгай хэрэгцээтэй хүүхдийг дэмжих нь" судалгаа нь

63

what special support and attention does a student with special needs get тусгай хэрэгцээтэй сурагчид ямар дэмжлэг, анхаарал шаардлагатай вэ?

64

and what was the impact on the development of the child. хүүхдийн хөгжилд ямар үр нөлөөтэй бэ? гэсэн асуултуудад хариулдаг.

65

The comparative study of child development assessment systems Хүүхдийн хөгжлийн үнэлгээ болон

66

and the survey 'Supporting every child for Inclusive Education principle in Mongolia' "Монгол Улсын хүүхэд бүрийг тэгш хамруулан сургах зарчмыг дэмжих нь" асуулгын харьцуулсан судалгааны үр дүн нь

67

found that children with special educational needs need support and that a further nation-wide study should be conducted. тусгай боловсролын хэрэгцээтэй хүүхдүүдэд дэмжлэг хэрэгтэй байгаа бөгөөд цаашид үндэсний хэмжээнд судалгаа явуулах шаардлагатай байгааг харуулж байна.

68

There is an urgent need to raise awareness and improve the knowledge about special needs with teachers and parents
Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд боловсрол олгоход хэрхэн дэмжлэг үзүүлэх талаар

69

and how children with special needs in education should be provided support.
багш, эцэг эхчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчлах зайлшгүй шаардлагатай байна.

70

What are the further perspectives on disability policies?
Хөгжлийн бэрхшээлийн талаар баримтлах бодлогын цаашдын төлөв юу вэ?

71

Policy documents should be updated and clarified in terms of inclusive education principles and values.
Тэгш хамруулах боловсролын зарчим, үнэт зүйл дээр тулгуурлан бодлогын бичиг баримтуудыг шинэчлэн боловсруулах хэрэгтэй.

72

A new law on special needs and inclusive education should be adopted and other legal provisions should be amended.
Тусгай хэрэгцээ болон тэгш хамруулан сургах боловсролын тухай хуулийг шинэчлэн боловсруулж бусад хуулийн зүйл, заалтуудыг өөрчлөх хэрэгтэй.

73

Training programs should be updated and include pre- and in-service teachers training in inclusive education.
Багш бэлтгэх хөтөлбөрүүдийг шинэчилж тэгш хамруулах боловсролын хөтөлбөрийг оруулж багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах хэрэгтэй.

74

For each program methodology textbooks and guidebooks on inclusive education
Хөтөлбөрийн дагуу сурах бичиг, гарын авлага, зөвлөмжийг боловсруулж

75

should be developed or translated and practice should be provided within each course.
орчуулах, практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх хэрэгтэй.

76

The development of the child should be assessed in accordance with international standard methodologies by a Child Development Support Centre.
Хүүхдийн хөгжлийг дэмжих төвөөс олон улсын стандарт аргачлалын дагуу хүүхдийн хөгжлийг үнэлэх хэрэгтэй.

77

A survey on the prevalence of children with special educational needs in Mongolia should be conducted.

Монгол улсын боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийн тархалтын судалгааг хийх хэрэгтэй.

78

The legal status of special needs teachers to work at regular schools should be elaborated.

Тусгай хэрэгцээт боловсролын багшийг ЕБС-д ажиллах боломжийг судлаж бүрдүүлэх хэрэгтэй.

79

What is the significance of the introduction of inclusive education for the educational system

Эрасмус+MELINC төслийн зорилго болох боловсролын тогтолцоонд

80

which is the purpose of the Erasmus+ MELINC project?

тэгш хамруулах боловсролыг нэвтрүүлэх нь ямар ач холбогдолтой вэ?

81

The project aims at updating the curriculum of teacher training in Mongolian universities

Энэхүү төсөл нь Монголын багш бэлтгэх их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрүүдийг

82

through the introduction of a modular course on 'Inclusive Education'.

тэгш хамруулах боловсролын агуулгаар баяжуулан хэрэгжүүлэх зорилготой.

83

It provides online training content and video tutorials and conducts face-to-face and online trainings.

Төслийн хүрээнд онлайн хичээл, видео хичээл боловсруулахаас гадна болон танхимын болон онлайн хэлбэрээр сургалт зохион байгуулагдана.

84

It establishes SEN centres for counselling and providing services for students with special needs in education and their families.

Тусгай хэрэгцээтэй хүүхдүүд болон Багш эцэг эхчүүдэд зориулагдсан Тусгай хэрэгцээт боловсролын зөвлөгөө мэдээллийн төв байгуулагдана.

85

The Mongolian National University of Education will introduce modules on inclusive education in a number of programs.

МУВИС нь тэгш хамруулах боловсролын багш бэлтгэх, давтан бэлтгэх, ахисан түвшний тэгш хамруулах боловсролын модулийг хэрэгжүүлнэ.

86

It will also operate the SEN counselling centre and provide advice and support to students with special needs in education
Түүнчлэн Тусгай хэрэгцээт боловсролын зөвлөгөө мэдээллийн төвөөр дамжуулан Монгол улсын төвийн бүсийн тусгай хэрэгцээтэй сурагчид,

87

and to their families in the central part of Mongolia.
тэдний эцэг эхчүүд, гэр бүлд зөвлөгөө, дэмжлэг өгч ажиллана.

88

Dornod University will introduce modules on inclusive education in a number of programs.
Дорнод Их сургууль мөн тэгш хамруулах боловсролын чиглэлээр хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

89

It will also operate the SEN counselling centre and provide advice and support to students with special needs in education
Мөн Тусгай хэрэгцээт боловсролын зөвлөгөө мэдээллийн төвөөр дамжуулан зүүн бүсийн тусгай хэрэгцээтэй сурагчид,

90

and to their families in the eastern part of Mongolia.
тэдний эцэг эхчүүд, гэр бүлд зөвлөгөө, дэмжлэг өгч ажиллана.

91

Khovd University will introduce modules on inclusive education in the Bachelor of Pedagogy and in the Master of Pedagogy.
Ховд Их сургууль нь тэгш хамруулах боловсролын чиглэлээр бакалавр болон магистрын түвшиний хөтөлбөр хэрэгжүүлэх ба

92

It will also introduce a mandatory short-term in-service teacher training course
баруун бүсийн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулан

93

and an elective short-term training for secondary school teachers in the region.
богино хугацааны багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулна.

94

It will also operate the SEN counselling centre and provide advice and support to students with special needs in education
Түүнчлэн Тусгай хэрэгцээт боловсролын зөвлөгөө, мэдээллийн төвөөр дамжуулан

95

and to their families in
the western part of Mongolia.

Монгол улсын баруун бүс нутагт амьдарч буй тусгай хэрэгцээтэй сурагчид,
тэдний гэр бүлд зөвлөгөө өгч дэмжиж ажиллана.